АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

# ЧИМЭЭГҮЙ ҮНЭН




Зохиолч: Б.Цолмон,
Б.Оюунчимэг

Зураач: М.Болортуяа





NEPKO Kids



# Шинэ орчин

Анар маргааш юу болох бол гэхээс нойр нь хүрэхгүй догдолж байлаа. Эднийх нэг сарын өмнө нийслэл хотод нүүж иржээ.

Маргааш 9 сарын 1-ний өдөр. **Анар шинэ сургуульд орно.** Шинэ найзуудтай болно. Нүүж ирснээсээ хойш тоглох ч найзгүй байсаар уйдаж эхлээд байсан юм. **НАЙЗ НӨХӨДТЭЙ БОЛЖ АМЖААГҮЙ** болоод ч тэр үү амьдарч байсан тосгоныхоо найзуудыг санагалзах нь шинэ орчинд дасахад нь нэрмээс болох аж.







Тэдний тосгоныхон нэгнээ андахгүй, Анар өдөржин найзуудтайгаа гадаа тоглох ч тосгонд байх өндөр настны асрамжийн газарт **чөлөө зайгаараа ус зөөж, түлээ хагалж** тус болдог байлаа. Тосгоны амьдрал үнэхээр завгүй өнгөрдөг байв.

Харин шинэ газарт нүүж ирснээс хойш **тэр хийх юмаа олж ядах болжээ.** Аав, ээж хоёр нь өглөөнөөс орой хүртэл завгүй ажиллах тул тэр өдрийг ихэвчлэн ганцаараа өнгөрөөнө. Гадаа гарч сагсны талбай орсон боловч тэнд өөрийнхөө үеийн хүүхдүүдтэй таарсангүй.

# 9 сарын 1

## Анарын хүсэн хүлээсэн өдөр.

Бүтэн сар ганцаар шахам өнжихдөө тэр шинэ ангийнхныгаа дотроо хэдэнтээ төсөөлөөд амжжээ. Ангийнхан нь түүнийг халуун дотноор хүлээж авах болов уу, хөдөөний хүүхэд гэж гадуурхах болов уу, найзтай болж чадах болов уу гэхчлэн бодсоор түүний догдлол эцэстээ санаа зовнил болж хувирах нь тэр.

Багш нь түүнийг самбарын өмнө гаргаад, “Танилцаарай хүүхдүүд ээ, Анар өнөөдрөөс та нартай хамт энэ ангид суралцах болно. Өмнөх сургуульдаа **Анар маань сурлагаараа тэргүүлдэг хүүхэд** байсан гэсэн. Та нарт Анараас суралцах зүйл их байгаа гэж бодож байна. Бас шинэ найздаа тусалж, сургуулиа танилцуулаарай” гэлээ.







Сурагчид шинэ хүүхдийг сонирхон харах ажээ. **Ичимхий, даруухан,** сулхан дуутай түүнийг хөвгүүд хөл бөмбөгийн багтаа авах эсэхээ дор бүрнээ дэнсэлж байх шиг. Охидын сонжиж, шохоорхсон харцнаас ичмээр ч юм шиг.

# Дасан зохицов

Анар тэр өдрөө найзтай болж чадаагүй ч ангийнхан нь түүнийг таатай хүлээж авчээ.

Шинэ сургууль нь соньхон, ар араасаа тэмцээн, уралдаан, арга хэмжээ, тоглолт гээд хүүхэд бүр дор бүрнээ ямар нэг зүйлд бэлдээд **ӨДРИЙГ ТУН ЗАВГҮЙ ӨНГӨРӨӨДӨГ** нь Анарт маш их таалагдаж байв.



Багш нь түүнийг орчиндоо дасан зохицоход нь туслахыг хүсээд, ангийн дарга Гэрэлийн дэргэд суулгажээ. **Гэрэл түүний яг эсрэг дүр** гэмээр. Тэр дуу шуутай, бодож байгаа зүйлээ шулуухан хэлдэг зантай. Анар түүнээс хэрэгтэй бүх мэдээллээ нэг өдрийн дотор бүгдийг авав.

Удахгүй "**УЛСЫН УРАН ИЛТГЭЛИЙН ТЭМЦЭЭН**"-д сургуулиа төлөөлөн оролцох багийг сонгон шалгаруулах тухай сурагч бүр ярих болов. Сурагчид жил бүр энэ тэмцээнд идэвхтэй оролцдог. Учир нь тэдний сургууль өнгөрсөн х**оёр жил дараалан аварга болсон ажээ.** Гэрэл ч бас энэ тэмцээнд идэвхийлэн бэлдэж байгаагаа хэлээд, Анарыг хүсвэл илтгэгчдийн шалгаруулалтад орж болно гэдгийг тайлбарлав.

Анарын хувьд тэр нэг өдрийг хүртэл бүх зүйл ийн **ТАЙВАН, НАМ ЖИМ** байсан юм...





# Гайтай шийдвэр



Багш ирц бүртгэсний дараа нэг зарлал дуулгав. “Уран илтгэлийн улсын уралдаан болоход яг нэг сарын хугацаа үлдсэн байна. Сургуулийн захиргаанаас хугацаа хэмнэж, илтгэлээ сайн бэлдэх цаг олгох үүднээс сонгон шалгаруулалт явуулалгүй оролцогчийг сонгох шийдвэр гаргажээ. Иймд багш нь та нарын ирц, сурлагын дүн, идэвхийг харгалзан ангиасаа хоёр хүүхдийг сонгохоор боллоо. Гэрэл, Анар хоёр энэ удаагийн уралдаанд сургуулиа төлөөлөн оролцоно. Хүүхдүүд ээ, хоёр найздаа баяр хүргэцгээе!” гэв.







Энэ үнэхээр гэнэтийн шийдвэр байлаа! Бүгд цочирдон гайхжээ. Хэн ч алга ташсангүй. **Шударга бус санагдаж байлаа.**

“Багш аа, яагаад энэ хоёрыг сонгосон юм бэ?” гэж урд эгнээнээс Дэлгэр тэсэлгүй асуув.

“Багш нь тайлбарласан шүү дээ. Та нарын ирц, сурлагын дүн, идэвх оролцоог харгалзан сонгосон гэж. Анар өмнөх сургуульдаа маш сайн сурдаг байсан. Гэрэлийн тухайд маргах хүн гарахгүй гэж бодож байна” хэмээн хэлтэл **ДАРААГИЙН ХИЧЭЭЛИЙН ХОНХ ДУУГАРЧ**, Англи хэлний багш хичээлээ заахаар орж ирэв.

# Чимээгүй дургүйцэл

Хүүхдүүдийн шивэр авир хийх дуу Англи хэлний багшийн хичээл эхэлж буйг сануулсан анхааруулгаар сая нэг намжив. Ангийн багшийн шийдвэрт **зарим сурагч сэтгэл дундуур** байгаа нь илт. Харин Анар энэ мэдээг яаж хүлээж авахаа мэдэхгүй самгарджээ. Дотроо баярлаж байсан ч, багш нь түүнд гэнэт ийн давуу байдал олгосонд **СЭТГЭЛ НЬ ТАВГҮЙ БАЙЛАА.**



Хичээлийн дараа Анар, "Багш аа, би... илтгэлийн тэмцээнд оролцох болсондоо баярлаж байгаа ч, **хүүхдүүд дургүйцэж байгаа болохоор**..." гээд түгдэрсэнд ангийн багш яриаг нь таслаад, "Санаа зоволтгүй дээ. Тэмцээндээ сайн бэлдээрэй" гээд явж оджээ.

Хөл бөмбөг хамт тоглодог хөвгүүд тэр өдөр "Эрт харилаа" гээд Анартай тоглолгүй **бүгд хэлэлцсэн мэт** нэг нэгээрээ үг дуугүй тарав.

# Цуу дэгдсэн нь

Үдийн хоолны завсарлагаанаар хамт суудаг найзууд нь Анараас дөлөн, түүнд суудал үлдээсэнгүйд Анар чимээгүйхэн холдсоор, буйдхан буланд ганцаар хооллов. Анар найзуудаа яагаад түүнийг үл тоож байгааг гадарлаж байсан ч **нүүр тулан асуухаас зайлсхийжээ.** Түүнд ганцаараа юм ярихгүй суух эвгүй санагдсанд тэр цүнхнээсээ чихэвчээ гаргаж зүүгээд, дуу тоглуулалгүй бодол болон сууж байтал хоёр ширээний цаана суух охидын яриа сонсогдов.

"Анар бид нартай үг дуугарахаа больжээ" гэж Отгоог хэлэхэд, түүний өөдөөс харан суух Сэргэлэн,

"Багшийн хамаатан гэдгийг нь биднийг мэдээгүй гэж бодсон юм байх даа. Түүнээс юу боллоо гэж багш түүнийг илтгэлийн тэмцээнд **сонгон шалгаруулалтгүй** оруулна гэж. Тийм биз дээ?" гэв.

Анарт өөрийнхөө тухай худал яриаг сонсох эвгүй байсан ч юу хэлж, хэрхэхээ мэдэхгүй байсан учраас тэдний яриаг **бачимдах, гомдох** зэрэгцэн сонссоор суулаа.







“Үгүй
ээ, Анар өмнөх
сургуульдаа маш сайн сурдаг байсан гэж
9 сарын 1-нд орж ирэхэд нь багш хэлж
байсан шүү дээ. Тийм байхад тэмцээнд
оролцоход **БОЛОХГҮЙ ЮМ БАЙХГҮЙ ШҮҮ ДЭЭ**” гэж Туяа
түүнийг өмөөрсөнд Сэргэлэн хөмсгөө
зангидан,

“Чи ч бас **хамаатан нь юм биш биз?** Тэгээд хамаатнаа өмөөрөөд ” гэсэнд
Туяа гайхширан,

“Яагаад чи биднийг багшийн хамаатан
болгоод байгаа юм бэ? **БИ ЛАВ БАГШТАЙ ЯМАР Ч ХАМААРАЛГҮЙ ШҮҮ**” гээд
ширэв татан, уурлаад босож явав.





“Яаж ингэж **санаандаа орсон зүйлээ жинхэнэ мэт** ярьж болдог байна аа” гэж хэлмээр байсан ч Анар өөрийнх нь тухай худал **хов жив яриаг** залруулалгүй өнгөрчээ.

## Буруу ойлголт

Төд удалгүй “Шинэ сурагч Анар ангийнхаа багшийн хамаатан гэнэ” гэх яриа сургууль даяар тарсан байлаа. Найзууд нь нэг нэгээр дөлөн, **үг дуугарахаа болиод** байсан бол, одоо хүүхэд бүр түүн рүү жигтэй хараад байх шиг санагдав. Үнэхээр ч бүгд түүнийг дотроо буруутган, багшийн хамаатан болохоор сонгон **шалгаруулалтгүй тэмцээнд оролцох эрх авсан** гэх “дүгнэлт”-ийг гаргасан бололтой.

Ширээний найз Гэрэл нь хүртэл **түүнтэй ярилцахаа больжээ**. Байдал ийм таагүй болсон атал Анар өөрийгөө бусдад ойлгуулах гэж ямар ч хичээл зүтгэл гаргасангүй. **Үнэндээ юу хийхээ мэдэхгүй байсан** хэрэг л дээ.



# Ганцаардал

Оройн хоолны үеэр, аав нь түүнээс “**Өнөөдөр хэр өдөр байв?**” гэж асуусанд Анар, “**Дангүй шүү.** Би улсын уран илтгэлийн тэмцээнд орохоор болсон” гэв.



“Яасан сайхан баяртай мэдээ вэ! Ээж нь хүүгээрээ бахархаж байна шүү. **Миний хүү сайн бэлдээрэй дээ”** гэж ээж нь баярлан дуу алдав.

“Гэхдээ чиний царай нэг л тавгүй байх чинь. Миний хүү хичээл, тэмцээн гээд ядарч байгаа байлгүй. Эртхэн унтаж амраарай” гэж **аав нь санаа зовнингүй** хэллээ.



Анар сургууль даяараа түүнийг багшийнхаа хамаатан гэж цуу дэгдсэнээс үүдэн **найзгүй болж, ганцаардаж байгаагаа** хэлж чадсангүй. Тэмцээнд оролцох болсон нь баяртай мэдээ атал ингэж **сэтгэл гонсгор** байгаагаа яаж тайлбарлахаа тэр мэдэхгүй байлаа.



# Гэрэлийн эргэлзээ арилав

Хэд хоногийн дараа, завсарлагаанаар Гэрэл Анарыг гүйцэж ирээд, нүүр рүү нь эгц харан зогсоод, “**Чи үнэхээр багшийн хамаатан юм уу?**” гэж шулуухан асуув. Анар гайхан хэдэн хором дуугарсангүй. **Тэгээд толгой сэгсрэв.**

"Тэгвэл яагаад юу ч хэлдэггүй юм бэ? Сургууль даяар чамайг багшийн хамаатан болохоор илтгэлийн тэмцээнд оролцох эрх авсан гэж ярьж байна. Үүнээс болоод хэн ч **чамтай найзлахыг хүсэхгүй**, дуугарахгүй байгаа биз дээ. Чи яагаад буруу ойлголт авсныг нь **залруулан хэлэхгүй байгаа юм бэ?**" гэж түүний өмнөөс бухимдан хэлэв.



“Хэллээ гээд өөрчлөгдөнө гэж үү? **Хэн ч намайг сонсохгүй шүү дээ**” гэж Анар дуулдах төдий шивнэн хэлэв.

Түүнийг ийм дуугүй, хулцэнгүй байгаад бухимдсан Гэрэл “**Би лав сонсох байсан.** Оролдож үзээгүй байж үр дүнг нь таавварлаж болохгүй шүү дээ” гэж **ширүүхэн хэлээд**, өөрийг нь хүлээн холгүй зогсож байсан охид руу эргэлээ.



# Юу чухал вэ?

Анар тэр өдөр Гэрэлийн **хэлсэн үгийг удтал бодов.** “Оролдож үзээгүй байж үр дүнг нь **тааварлах болохгүй шүү дээ**” гэх түүний үг толгойд нь цуурайтан давтагдсаар байлаа. Ийн бодолд дарагдаад хичээлийн дараа **ганцаар үлдсэнээ ч анзаарсангүй.**


"Багш нь чамтай ярилцъя гэж бодоод байсан юм. **Багшид нь хэлэх зүйл байна**" гэх багшийн дуунаар АНАР САЯ СЭХЭЭ АВЧЭЭ.

Түүнийг ойрд хичээлдээ **идэвх муутай** оролцох болсныг багш нь анзаараад зэмлэх гэж байна гэж тэр боджээ. Зэмлүүлэхдээ бэлдэн, урд эгнээний эхний ширээнд очиж суулаа.

“Багш нь чамайг тэмцээнд оролцох хоёр сурагчийн нэгээр сонгосноос үүдээд асуудлаа дэгдсэнийг мэдсэнгүй. Заримдаа хүмүүс чимээгүй байгааг чинь буруу ойлгодог. **Өөрийгөө хамгаалж, үг хэлж байхгүй бол бусдын буруу ойлголт үнэн мэт болчихдог шүү**” гээд, Анарыг мөн л дуугаа хураасаар байсанд “Гэрэл надад болсон явдлыг тайлбарлаж хэлсэн” гэв.

Багш нь түүнд илтгэлээ хэрхэн унших тухайд зөвлөмж өгч, хичээнгүйлэн бэлдэхийг захив. “Хүүхдүүд чамайг яагаад илтгэгчээр сонгосныг удахгүй мэднэ ээ.” Багшийн ингэж хэлсэн нь түүнд гэнэтийн дохио шиг л санагдав.



Тэр өдрөөс хойш Анар тэмцээний илтгэлээ бэлдэж эхлэв. Харин энэ удаа зөвхөн амжилтын төлөө бус, **өөрийгөө ойлгуулахын тулд...**

# Тэмцээний өдөр

Тэмцээний өдөр боллоо. Анарын ээлж ирж, тайзан дээр алхахдаа **түүний гар чичирч, дотор нь пал хийж** байв. Гэсэн ч тэр Гэрэлийн зөвлөснөөр тайвшрах хүртлээ **хэдэнтээ гүнзгий амьсгаа** авлаа.

“Ой модоор хүрээлэгдсэн алс бөглүү нэгэн бяцхан тосгонд Элия нэртэй хүү амьдран суудаг байжээ. Тэр дуу цөөтэй, сайхан сэтгэлтэй, үргэлж бусдын үгэнд ордог, дуулгавартай жаал байв. Нэг өдөр хэн нэг нь Элия хүүг зах дээрээс **мөнгөн бөгж хулгайласан тухай** өөр нэгэнд шивнэж л дээ. Яг үнэндээ Элия тэр бөгжийг шохоорхон харснаас цаашгүй. Гэтэл энэ цуу яриа хуурай **өвсөнд дэгдсэн түймэр шиг л** тархжээ.”





Анар тайван, тод дуугаар цааш үргэлжлүүлэв. "... **Хэн ч түүнээс юу болсон тухай** асуугаагүй юм. Худалдаачин Элияг ил тодоор буруутгаагүй ч, түүнтэй мэндлэхээ больжээ. Бүгд энэ **шуу яриаг сонссон ч чимээгүй байхыг сонгосон** юм. Элия ч мөн адил. Тэр эсэргүүцэж, өөрийгөө өмөөрсөнгүй, зүгээр л чимээгүй байхаар шийджээ. **Тэр өдрөөс эхлэн хүү гэрээс гарахаа больжээ.** Эцэст нь түүнийг сургууль дээр үзэгдэхээ больсныг ангийнхан нь анзаарах үед бүх зүйл оройтсон байлаа..."

Үзэгчид бүгд чих тавин чимээгүй сонсоно. Анарын өгүүлэх **түүх бүгдээ нэгийг бодогдуулжээ.** Зарим нь энэ түүхээр тэр шударга бусын өмнө чимээгүй өнгөрч болохгүйг сануулсан гэж үзсэн бол, бусад нь **хов жив гэмгүй нэгнийг ч хохироож** болохыг ойлгов.









# Чимэгүй ялалт

Хожим нь ангидаа эргэн ирэхэд нь олон хүүхэд Анарыг инээмсэглэн угтав. Зарим нь **"Сайхан шатгаа байлаа"** хэмээн урмын үгээр шагнасан юм.



Сэргэлэн анхнаасаа Анарыг үл тоож, "багшийн хамаатан" хэмээн бусдад цуу тараасан нь **өөрийнх нь атаархлаас болсон байв.** Тэрээр өөрөө илтгэлийн тэмцээнд оролцохоор бэлдэж байсан ч СОНГОГДООГҮЙ ТУЛ СЭТГЭЛ ДУНДУУР БАЙЖЭЭ.

Анарын илтгэл сурагчдад нэгийг бодуулж, хүүхдүүд **хэн нэгний үгээр бусдыг дүгнэх нь** өрөөсгөл гэдгийг ойлгожээ. Харин Сэргэлэн өөрийгөө зөвтгөхөөр, хүүхдүүдэд хандан: "За яах вэ, багш л тусалсан байгаа биз. ӨӨРӨӨ БЭЛДСЭН Ч ЮМ УУ, БҮҮ МЭД..." хэмээн бувтнав.



Гэхдээ энэ удаа түүнийг хэн ч дэмжсэнгүй, хүүхдүүд Сэргэлэнд илтгэл алдрав. Гэрэл түүний хэлсэнд дургүйлхэн: "**Битгий хүн гүтгээд бай.** Анар чадварлаг байлаа, чи өөрөө нүдээрээ харсан биз дээ?" гэж **шулуухан хэлэв.**



Сэргэлэн чимээгүй болж,
нүүр нь улайв. Тэр өмнөх
шигээ хүмүүсийг удирдаж
чадсангүй.



Хүүхдүүдийн ийн ярилцахыг багш нь чимээгүй сонсон, ажиглаж байлаа. Гэрэл өмнө нь Анарын тухай **цуу яриа дэгдсэнийг л хэлснээс биш, хэн тэр яриаг тараасныг дурдаагүй** байж. Багш хэргийн эзэн Сэргэлэн болохыг төвөггүй таамаглав.

Багш Сэргэлэнтэй ярилцахаар **түүнийг хичээлийн дараа үлдэхийг хүсэв.**



"Багш аа, намайг уучлаарай. **Би ахиж худал хов ярихгүй.** Анарыг тэмцээнд оролцох болсонд уур хүрээд байсан юм..." гэсээр Сэргэлэнг гэмшин өгүүлсэнд БАГШ ЯРИАГ НЬ ТАСЛААД.

"Багш нь ч бас чамаас уучлалт гуйя. Сонгон шалгаруулалтыг гэнэт цуцалсанд энэ тэмцээнд оролцохыг хүсэж байсан чамтай адил олон сурагчдын урмыг хугалсан болов уу. **Худал хов тараасан тухайд** чамайг гэмээ ухаарсныг харлаа. ХУДАЛ ҮГИЙГ МЯНГА ДАВТАХАД ҮНЭН МЭТ БОЛДОГ гэсэн үг байдаг шүү дээ" гээд дараагийн удаад шударга шийдвэр гаргахын тулд АНГИАРАА ХЭЛЭЛЦЭН, САНАЛ ХУРААЖ БАЙХАА амлав.

Сэргэлэн багштайгаа ойлголцсондоо **санаа нь амарсан боловч** жинхэнэ гомдоосон найзаасаа УУЧЛАЛ ГУЙГААГҮЙ болохоо ойлгоод Анарыг хайхаар явлаа.



## Эцэст нь...

Анарын ангийнхан аливаа зүйлд түн **хариуцлагатай хандаж,** басхүү нээлттэй хэлэлцэж байж шийдвэр гаргаж сурчээ.

Багш нь хүүхэд бүрийн саналыг хүндэтгэн, **шударга хүүхдүүдийнхээ дуу хоолойг** сонсох болсноор одоо тэд ангиараа **эрүүл, шударга хариуцлагатайгаараа** сургуульдаа ч **үлгэрлэх болжээ.**

# ЧИМЭЭГҮЙ ҮНЭН

Зохиолч:
Б.Цолмон, Б.Оюунчимэг

Зураач:
М.Болортуяа

Анхны хэвлэл

Редактор:
Л.Эрдэнэжаргал,
З.Баасанням, Б.Тэрбиш

Эх бэлтгэл:
Н.Бямбацогт



Зохиол болон зургийн эрх
© Авлигатай тэмцэх газар 2025
Хэвлэлийн эрх © Нэпко Кидс 2025



Энэхүү номыг Авлигатай тэмцэх
газрын Урьдчилан сэргийлэх,
соён гэгээрүүлэх хэлтсийн
захиалгаар бүтээв

НЭПКО КИДС


All rights reserved.

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрхийг
хуулийн дагуу хамгаалсан болно.
Бүтээлийг бүтнээр буюу хэсэгчлэн
хувилах, нийтлэх, микрофильм
хийх, электрон системд оруулах
болон бусад ямар нэг хэлбэрээр
олшруулахыг хориглоно.



НЭПКО КИДС хэвлэлийн газарт
эхийг бэлдэв.

Баянзүрх дүүрэг, 25-р хороо, UB
Tower Plus, 709 Улаанбаатар 13000,
Монгол Улс

www.nepkokids.mn

ISBN: 978-9919-532-15-4


